

**Сүхбаатар дүүрэгт амьдарч буй настнуудын дунд насны доройтлын  
хүндрэлийг үнэлсэн нь**

*Г.Мөнхбат<sup>1</sup>, Н.Оюунтуяа<sup>2</sup>, Ч.Одгэрэл<sup>2</sup>*

*<sup>1</sup>Сүхбаатар дүүргийн ЭМТ*

*<sup>2</sup>Геронтологийн үндэсний төв*

**Үндэслэл:**

Одоогийн байдлаар дэлхий дахинд 700 сая орчим ахмад буюу 60 дээш насны хүн байгаа бөгөөд 2050 он гэхэд ахмадууд дэлхийн нийт хүн амын 20 хувийг эзэлж, 2 тэрбумд хүрэх төлөвтэй байна. Манай оронд 3.2 сая хүн амын 6,7 хувь /231840/-ийг 60 болон түүнээс дээш насны хүн ам эзэлдэг. Нийт настан хүн амын 46% /97079/ Улаанбаатар хотод оршин суудаг ба 6,5 % /6985/ эрүүл мэндийн 4,5 бүлэгт хамрагддаг. Сүхбаатар дүүрэгт одоогийн байдлаар 4,5 бүлгийн нийт 982 ахмад байдаг. Насны доройтол нь нийгэм, эдийн засаг, оршин суугаа улсын дотоодын нийт бүтээгдэхүүн, эрүүл мэндийн зардлын өртөг , олон эмийн хэрэглээг ихэсгэдэг. Ахмад настнуудын дунд хэвтрийн, гэрийн тусламж үйлчилгээнд хамрагдаж байгаа 700 гаруй настны судалгаа хийгдсэн ч насны доройтлын тархалт, хүндрэлийг судалсан судалгаа байхгүй байна. Иймээс доройтлын тархалт хүндрэлээр хийгдэж буй анхы судалгаа юм.

**Зорилго:**

Гэрийн тусламж үйлчилгээгээр дамжуулан хэвтрийн ахмад настнуудад доройтол болон түүний хүндрэлийг тодорхойлж үнэлгээ өгөх

**Зорилт:**

1. Гэрийн тусламж үйлчилгээнд хамрагдаж буй настнуудын дунд доройтлыг илрүүлэх, дортойтолд хүргэж буй хүчин зүйлсийг тодорхойлох
2. Насны доройтлын үед сэтгэлзүйд гарах өөрчлөлтийг судлах
3. Насны доройтлын хүндрэлийг судлах

**Материал арга зүй:**

Сүхбаатар дүүргийн харъяа амьдардаг эрүүл мэндийн IV,V бүлгийн болон өндөр настнуудад гэрээр настны цогц үнэлгээ хийж, дортойтол, түүний хүндрэлийг илрүүлэх стандарт асуумжуудаар үнэлгээг хийсэн. Насны доройтлыг илрүүлэх Гронингийн асуулга, настны бие даах чадварын Катзийн үнэлгээ, настны багаж хэрэгсэлтэй ажиллах чадварыг Лавтоны үнэлгээ, явганаас унах эрсдлийг үнэлэх Морсын шалгуур, настны танин мэдэхүйн чадварыг Minimental examnation test, настны хоол тэжээлийн байдлыг үнэлэх Vellas-ийн аргачлалаар, доройлтын хүндрэлийг үзлэгээр тус тус тодорхойлж насны ангилал, хүйсээр ялгаатай байдлыг тодорхойлж үнэлсэн.

### **Үр дүн:**

Сүхбаатар дүүргийн харъяа 55-аас дээш настай нийт 122 настанд судалгаанд хамруулж гэрийн үзлэг, настны цогц үнэлгээг хийсэн. Судалгаанд хамрагдагсдын дундаж наслалт  $73 \pm 7.9$  жил байв. Судалгаанд хамрагдсан 122 настны 49 (40.2%) эрэгтэй, 73 (59.8%) эмэгтэй настнууд байсан. Эрэгтэй  $73.3 \pm 8.4$ , эмэгтэй  $72.8 \pm 7.7$  байсан ( $p=0.039$ ). Судалгаанд хамрагдагсдыг доройлтын үнэлгээгээр үнэлэхэд 80.3 хувь нь доройтолтой байсан ( $p<0.001$ ). Нас ахих тусам доройтолд орох эрсдэл ихсэж, доройлтын хүндрэл нэмэгдэж байсан. Доройтолд оруулсан үндсэн өвчинг эрхтэн тогтолцоогоор судлаад үзэхэд зүрх судасны өвчин 43.4%, хоол боловсруулах эрхтний эмгэг 5.7%, амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг 4.1%, хавдар 1.6%, мэдрэлийн өвчин 25.4%, нүдний өвчин 4.9%, үе мөчний өвчин 14.8% байсан. Насны доройтолтой настны 69.7 хувь нь архаг өвдөлттэй улмаас байнгын өвдөлт намдаах эм уудаг байсан. Доройтолтой настны сэтгэлзүйн байдлыг судлаад үзэхэд 16.4 хувь нь танин мэдэхүйн чадварын дундаас дээш сулралтай, 7.4 хувь нь зан төрхийн өөрчлөлттэй, 9.8 хувь нь сэтгэл гутралтай байсан. Доройлтын хүндрэлийн судлаад үзэхэд 1 хүндрэлтэй 71 (61.5%), хоёр хүндрэлтэй 10 (8.2%), гурван ба түүнээс дээш хүндрэлтэй 13 (10.6%) байсан. Хүндрэлийг судлаад үзэхэд байршлын хаван 25.5%, хоолны дуршил буурах 23.5 %, өтгөн хаталт 15.6%, хэвтрийн хатгаа 13.7%, тураал 7.8%, цооролт 3.9% тус тус эзэлж доройлтын 12 хүндрэл дотор тэргүүн байруудыг эзэлж байсан. Нас ахих тусам доройлтын хүндрэлийн тоо нэмэгдэж байсан ( $p<0.05$ ).

**Дүгнэлт:** Сүхбаатар дүүрэгт амьдарч буй эрүүл мэндийн IV,V бүлгийн настнуудын дунд доройтол 80.3% тохиолдож байна. Зонхилох хүндрэлийг судлаад үзэхэд настны асаргаа, сувилгаатай холбоотой хүндрэл болон настны хоол тэжээлийн дуталтай холбоотой хүндрэл зонхилон үүсч байгаа нь настны өвөрмөц урт хугацааны асаргаа сувилгааны салбар хэрэгтэй байгааг харуулж байна. Эсвэл доройтолтой настны асран халамжлагч нарт настны асаргаа сувилгааны талаар эрүүл мэндийн боловсрол олгох хэрэгцээтэй байгааг харуулж байна.